



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/91

Алтай хот

**Аймгийн алдарт уяач цол  
олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, улсын бүс, аймгийн баяр наадам, аймгийн бүсийн уралдаануудад үндэсний морин спортын төрөлд үзүүлсэн амжилтаараа хууль, журамд заасан болзол хангасан уяачдад "Аймгийн алдарт уяач" цол олгож, нэрсийг хавсралтаар баталсугай.

2."Аймгийн алдарт уяач" цолны үнэмлэхийн зардалд шаардагдах 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс ( Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20<sup>22</sup> оны  
 02 дугаар сарын 10 ны өдрийн 1301 дугаар  
 захирамжийн хавсралт

АЙМГИЙН "АЛДАРТ УЯАЧ" ЦОЛ ОЛГОХ  
 УЯАЧДЫН НЭР, ГАРГАСАН АМЖИЛТ

№	Овог, нэр	Сумын нэр	Үзүүлсэн амжилт			
			Улсын баяр наадам, улсын бүсийн наадмаас		Аймгийн баяр, түүнтэй дүйцүүлэх уралдаанаас	
1.	Даваажавын Чимэдрагчаа	Жаргалан			3	4
2.	Зоригтбаатарын Шижирбат	Дэлгэр	1	2	2	2
3.	Очирын Мөнхбаяр	Бигэр			1	4
4.	Шархүүгийн Онолбат	Есөнбулаг			5	9
5.	Гансүхийн Хадбаатар	Дарив			1	11
6.	Зоригийн Энхбаатар	Баян-Уул			2	5
7.	Самбуугийн Баттөмөр	Халиун		1	2	3
8.	Допиронгийн Чагнаадорж	Тайшир			2	7
9.	Балжиннямын Ууганбаяр	Тайшир			2	6
10.	Санжаахүүгийн Дүгэржав	Халиун		3	2	4
11.	Сосорбурамын Лхагва-Эрдэнэ	Эрдэнэ			2	3
12.	Даш-Очирын Батмагнай	Хөхморьт			1	2
13.	Сүрэнхоролын Азжаргал	Бигэр сум			1	10
14.	Жамъяны Ванчиг	Дэлгэр сум			2	6

\_\_оОо\_\_